



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/472

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Швейцарын хөгжлийн аентлаг, Нийгмийн эгэх хариуцлагын Дэлхийн түншлэлийн санхүүжилтээр Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” буюу MASAM II төслийг Хөвсгөл аймагт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлыг хэсгийн ахлагч: Г.Базар (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Гишүүдэд:

Б.Оюунтуяа (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Цэцэгмаа (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Д.Түвшинбаяр (Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Отгонбаяр (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн дарга)
/Зөвшилцсөнөөр/

О.Дагиймаа (Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого үйл ажиллагаа зохион байгуулах мэргэжилтэн)

Б.Лхагваа (Хөвсгөлийн хөгжил, дэвшилд ТББ-ын тэргүүн)
/Зөвшилцсөнөөр/

Н.Отгонжаргал (Хайр, найдвар, гэрэл ТББ-ын гүйцэтгэх захирал)
/Зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга:

Д.Баасанцэцэг (Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

671 1011393

2.

2. Ажлын хэсгийн ажиллах чиглэлийг хавсралтаар баталсугай

3. Батлагдсан ажлын хэсгийн гишүүд ажиллах чиг үүргийн дагуу тухай бүр хуралдаж, үр дүнтэй ажиллахыг ажлын хэсгийн ахлагч болон гишүүдэд даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Холбооны
Холбооны
Холбооны

Аймгийн Засаг даргын 2022 оны
12 дугаар сарын 26 өдрийн
А/12 захирамжийн
хавсралт

**“МОНГОЛ УЛСАД ИЛ ТОД БАЙДАЛ, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ
НЭМЭГДҮҮЛЭХЭД НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ”
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ**

Төсөл хэрэгжүүлэхэд хамтран ажиллах ажлын хэсэг доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Нэг. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр:

1.1.2022 онд хэрэгжүүлсэн Сайн эмнэлэг, сэтгэлд нийцсэн үйлчилгээ аргачлалын үр дүнд үнэлгээ хийсэн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах

1.2. Мөрөн сумын 5 ӨЭМТ-өөр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа хийж холбогдох арга хэмжээ авах

Хоёр. Төсөв, төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр:

2.1.Улс, орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ӨЭМТ-д хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэлд иргэдийн оролцоотой хяналт үнэлгээ хийх боломж бүрдүүлэх, хамтарсан зөвлөмж боловсруулж хэрэгжилтийг хангах

2.2.Хөвсгөл аймгийн 2023 оны Иргэдийн төсөвт орох мэдээллийг бүрдүүлж, олон нийтэд түгээх

2.3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22 ны өдрийн 352 дугаар тогтоолын хэрэгжилтэд Хөвсгөл аймгийн ЗДТГ, Мөрөн сумын ЗДТГ-т үнэлгээ хийж, нөлөөлөл үзүүлж, сургалт, мэдээллээр хангаж, мэдээллийн ил тод байдлыг хангуулах

2.4.Цахим платформыг түгээх, дэлгэрүүлэх төлөвлөгөө боловсруулж сургалт, мэдээллээр хангаж хэрэгжилтийг хангуулах (PIMIS-Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем, Иргэдийн төсвийн эмхэтгэл, 1313.mn)

Гурав. Олон нийтэд мэдээлэл хүргэх чиглэлээр:

3.1.Төсвийн ил тод байдал, хөрөнгө оруулалтын үйл явцад иргэдийн оролцоог хангаж мэдээллээр хангах, шийдвэр гаргах нөхцлийг бүрдүүлэх

3.2. ИТХ, Төрийн байгууллага, ИНБ хамтран олон нийтэд мэдээлэл хүргэх